



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 1105

Баян-Өндөр сум

Хариу арга хэмжээг зохион байгуулах
тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, 34.2.3, Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Журам шинэчлэн батлах тухай" 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Журам заавар шинэчлэн батлах тухай" А/328 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. 2024 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Орхон аймгийн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд оролцогчдоос хоолны хордлогот халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэй үнэлэгдсэн тул тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хоолны хордлогот халдварын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хоолны хордлогот халдварын үед ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс /Д.Жаргал/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /П. Хишгээ/-д даалгасугай.
3. Хоолны хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, үнэн бодит, мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж ажиллахыг олон нийттэй харилцах ажилтан /Б.Лхагвадэмбэрэл/-д үүрэг болгосугай.
4. Хариу арга хэмжээнд ажилласан албан хаагчдад холбогдох нэмэгдэл хөлсийг тооцож олгохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГА  Ц МӨНХЦЭЦЭГ

9043446 2020030036

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн
11/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Хоолны хордлогот халдварын үед хариу арга хэмжээг зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч: Эрүүл ахуй, халдвар хяналтын улсын байцаагч Б.Будсүрэн

№	Хариу арга хэмжээний багийн нэр	Гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Тандалт судалгааны баг	П.Отгонбилэг А.Хонгорзул А.Хонгорзул О.Анхбаяр Б.Батцэцэг Н.Мөнгөнцацралт	-Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн -Халдварын бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн -Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн -Эмийн чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн -Сэтгэл зүйч -Орчны эрүүл мэнд нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
2	Эрсдлийн харилцаа холбооны баг	Б.Лхагвадэмбэрэл Б.Солонго	-Олон нийттэй харилцах ажилтан -Эрүүл ахуй, халдвар хяналтын улсын байцаагч
3	Эмнэлгийн тусламж шуурхай хариу хэмжээний баг	П.Хишгээ Л.Цэрэнлхам	-Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн -Хүүхэд өсвөр үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн



Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 8 дугаар сарын 6 -ны өдрийн
М.Б. БУДСҮРЭН дугаар тушаалын хосрдугаар хавсралт

ХООЛНЫ ХОРДЛОГОТ ХАЛДВАРЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ШУУРХАЙ ЗОХИОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.08.06

Орхон аймаг					
№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах тушаалтан	албан	Хамтран ажиллах байгууллага
НЭГ. БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР					
1.	ХХДӨ, хоолны хордлогот халдварын хариу арга хэмжээний багийг томилж, мэргэжил арга зүйгээр хангах	2024.08.06	ЭАХХХУБ Б.Будсүрэн		ӨЗЭМТ-үүд
2.	Тандалт судалгаанд хамрагдсан, эмнэлзүйн шинж тэмдэг бүхий хүмүүсийг явуулын цэгээр шинжилгээнд хамруулах, урвалж оношлуур, хүний нөөцийн бэлэн байдал хангах	2024.08.06-08.08	ЭАХХХУБ Б.Будсүрэн		БООТ Нян судлалын лаборатори
3.	Халдвартын тасгаар тусламж үйлчилгээ авсан хүмүүсийг нян судлалын шинжилгээнд хамруулахад шаардлагатай нөөц бэлэн байдлыг хангах	2024.08.03- 2024.08.10	БООТ Халдвартын тасгийн эрхлэгч		Нян судлалын лаборатори
4.	СӨЭМТ-үүд ШГА эерэг гарсан буй халдварын хэсгийн бэлэн байдлыг хангах	08-р сарын 06-наас	АШТУ хариуцсан мэргэжилтэн А.Хонгорзул		СӨЭМТ-үүд
ХОЕР. МЭДЭЭЛЭЛ, ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЧИГЛЭЛЭЭР					
1.	ЭМС-ын 2019 оны А/527 дугаар тушаалын дагуу хам шинжийн тохиолдлын мэдээллийг урсгалын дагуу мэдээлэх	Тухай бүр	Холбогдох мэргэжилтэнд		Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
2.	Хоолны хордлогот халдварын сэжигтэй тохиолдлын мэдээллийг авсан даруйд	2 цагийн дотор	Хариу арга хэмжээний баг		ЭМБ-үүд

	эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээний дүнд ТҮТ идэвхижих				
3.	Хоолны хордлогот халдварын сэжигтэй тохиолдлын үйл явдлын мэдээллийг ШУН, дээд шатны байгууллагад мэдээлэх	2 цагийн дотор	Хариу арга хэмжээний баг	ХӨСҮТ, АЗДТГ	
4.	Эрсдэлийн явцын үнэлгээг хийх, идэвхижлийн зэрэг, түвшинг үнэлэх	72 цагийн дотор	Эрсдэлийн баг	ХӨСҮТ, ШУН	
5.	ӨЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд гэдэсний халдварт өвчний үеийн эмчилгээ, хяналт, тандалтын талаар сургалт зохион байгуулах	2024.08.07	АШТҮХМ А.Хонгорзул	БОЭТ, СӨЭМТ-үүдийн эмч мэргэжилтнүүд	
ГУРАВ. ТАНДАЛТ СУДАЛГАА, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР					
1.	Хоолны хордлогот халдварын үед ажиллах тандалтын багийг томилох	2024.08.03	Тандалтын баг	Соёл урлагийн газар	
2.	Тандалтыг цахимаар болон тандалтын багийн гишүүд утсаар холбогдож асуумж судалгаа авах	2024.08.03- 2024.08.06	Тандалтын баг	ЭМБ-ууд	
3.	Эмнэлэгт хандсан хүмүүст тандалт судалгаа хийх	2024.08.03-наас	Тандалтын баг	ЭМБ-ууд	
4.	ШГА эерэг гарсан хүмүүсийн ойрын хавьталд шинж тэмдгийн тандалт хийх, голомтод хариу арга хэмжээ авах	Тогтмол	ЭМГ-ын мэргэжилтэн П. Отгонбилэг	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	
5.	Хоол үйлдвэрлэлийн ажилтнуудыг нян тээгчийн шинжилгээнд хамруулах, эх уурхайг илрүүлэх	2024.08.05	ЭАХХХУБ Б.Солонго	БОЭТ Лаборатори	
6.	Хоол үйлдвэрлэлийн газарт хяналт шалгалт хийх, ЗШША явуулах	2024.08.03- 2024.08.24	ЭАХХХУБ Б.Солонго	ХХААГ, Прокурорын газар	
ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР					
1.	Хоолны хордлогот халдварын талаар мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх	Тухай бүр	Холбогдох мэргэжилтэн	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд	

2.	Өвчнөөс сэргийлэх сэрэмжлүүлэг, зурагт хуудас эрүүл мэндийн газрын веб сайтад байршуулах	Тогтмол	Олон харилцах Б.Лхагвадэмбэрэл	Орон нутгийн мэдээллийн байгууллагууд	хэвлэл,
----	--	---------	-----------------------------------	---------------------------------------	---------

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
 ЗАХХУБ *Б. Бүдсүрэн* Б.БУДСҮРЭН